



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/330

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эх үрсийн баярыг тохиолдуулан олон хүүхэд төрүүлж өсгөсөн, өндөр настай, байгууллагын харьяалалгүй, зорилтот бүлгийн ээжүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 3 440 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 3 440 000 төгрөг /Гурван сая дөрвөн зуун дөчин мянган/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5.24-д тусгагдсан "Ахмадаа ачлая" хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

00-01627  
D/Zax-A/330-Da

Аймгийн Засаг даргын 2019 оны  
05 дугаар сарын 27-ны өдрийн  
А/330 дугаар захирамжийн хавсралт

ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН, ӨНДӨР НАСТАЙ,  
БАЙГУУЛЛАГЫН ХАРЬАЛАЛГҮЙ, ЗОРИЛТОТ БҮЛГИЙН  
ЭЭЖҮҮДЭД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт /төг/
1	Жаргалант сумын ээжүүдэд	40 хүн	50000	2 000 000
2	Хөдөө 16 сумдын ээжүүдэд	48 хүн	30000	1 440 000
	Нийт			3 440 000

-oOo-